

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

2015 он

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
2015 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН АЖЛЫН АЛБАНААС ГАРГАВ

.....

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х.ТӨРТОГТОХ

**Хаяг:**

Увс аймаг, Улаангом Ө.Бадархын  
гудамж Нутгийн удирдлагын ордо 210-  
213 тоот Утас: 7045-2515, Факс: 7045-  
2214, мэйл: [info@khural.uv.gov.mn](mailto:info@khural.uv.gov.mn), Веб  
сайт: <http://Uvs.khural.mn>, Facebook: Увс  
аймгийн хурал

## АГУУЛГА

### НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Зохион байгуулсан сургалт зөвлөгөөний арга хэмжээ

Аймгийн ИТХ-с зохион байгуулсан “АЯН” арга хэмжээ

Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ аян

“Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” аян Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав

Зохион байгуулсан хэлэлцүүлэг

*Төвлөрсөн хүнс барааны захуудын дэд бүтцийг сайжруулах замаар, орчин нөхцийг сайжруулах нь ХЭЛЭЛЦҮҮЛЭГ*

*“Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний*

*удирдлагын тухай хуулинд өөрчлөлт оруулах санал авах” хэлэлцүүлэг*

Цахим засаглал нэвтрүүлэв

Хурлын төсвийн зарцуулалт:

*2015 оны зардлын зарцуулалт*

Сумдын ИТХ-ын ажлын талаар:

Мэдээлэл сурталчилгаа

### ХОЁР. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН

Аймгийн ИТХ-ын 9-р хуралдаанаар :

Аймгийн ИТХ-ын 10-р хуралдаанаар :

### ГУРАВ. ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан хөтөлбөр төлөвлөгөө

Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан дүрэм журам

Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан ОНӨААТҮГ

Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлт

ИТХ-ын хорооны үйл ажиллагаа

### ДӨРӨВ: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР

Хамтран ажилласан талаар:

Хөрөнгийн бүртгэл, Хяналт шалгалтын ажлын талаар:

Сургалт сурталчилгааны ажлын талаар:

Хувьчлалын талаар:

**ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ**

**ЗУРГАА: ЦАГААТГАЛЫН КОМИССЫН АЖИЛ**

Иргэдийн өргөдөл, хүсэлтэд хариу өгч, мэдээлэл зөвлөгөө өгөх чиглэлээр

Цагаатгагдсан иргэдийн нэр төрийг сэргээх талаар хэрэгжүүлсэн ажил

ЦАУЗБСалбар комиссын мэдээллийн бааз үүсгэв.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрлөг

**ДОЛОО. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**НАЙМ: БУСАД АЖИЛ**

**УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2015 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН****НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аймгийн ИТХ-ын 2013-2016 оны бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагааны чиглэлд тулгуурлан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, нэн ялангуяа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн орлогыг нэмэгдүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, ус рашаан ашиглагчдыг бүртгэлжүүлж төлбөрийг төсөвт бүрэн төвлөрүүлэх, орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт бүртгэлийг онлайн программд нэвтрүүлэн хянах, хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх, газрын харилцааны шинэтгэлийн бодлого хэрэгжүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ИТХ-ын хурал болон, тэргүүлэгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн биелэлт, баталсан хөтөлбөр, зорилтынхоо хэрэгжилтэд хяналт тавьж боловсронгуй болгох талаарх асуудлыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн санал, 2015 оны зорилтод суурилсан жилийн ажлын төлөвлөгөөг тэргүүлэгчдийн хурлаар эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилт, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, хөтөлбөр, төлөвлөгөө батлах, цахим засаглалыг дэмжих, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох гэсэн үйл ажиллагааг идэвхжүүлэхээр **“Оролцоонд тулгуурласан, ил тод нээлттэй байдлыг хангах”** уриан дор ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж сарын хуваарьт оруулж тэргүүлэгчид, хурлын хороод болон ажлын албанаас зохион байгуулах ажлаар нь ялгаж ажилтан бүрд хуваарилан 102 ажил, арга хэмжээг төлөвлөснөөс 97 ажил бүрэн хэрэгжиж 5 ажил төсвийн хүрэлцээгүйгээс хойшлогдож төлөвлөгөө 93.1 хувьтай биеллээ.

### Зохион байгуулсан сургалт зөвлөгөөний арга хэмжээ

Аймгийн ИТХ-ын төлөвлөгөөт болон Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран Аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгч, Нарийн бичгийн дарга нарт зориулсан **“Төлөөлөгчдийн манлайлал” сургалтад** 19 сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, аймаг, сумдын тэргүүлэгч, төлөөлөгч 150 хүн, аймгийн ИТХ-ын ажлын албаны 6 ажилтан тус бүр төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр сургалтад хамрагдаж нутгийн өөрөө удирдах байгууллагын манлайлах ур чадвар, бие даан шийдвэр гаргах төвшинг нэмэгдүүлэх төлөөлөгчийн бүрэн эрх, үүргээ хэрэгжүүлэн ажиллахад хяналт үнэлгээ шинжилгээ, судалгаа хийх арга зүй, <http://.uvs.khural.mn> дэд цахим хуудас хөгжүүлэх арга зүйд суралцсан үр дүнтэй сургалтад хамрагдлаа.

Конрад- Аденауэр сангийн санхүүжилтээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газраас хамтран зохион байгуулж буй **“Нутгийн удирдлагын манлайллыг хангах нь” сэдэвт сургалт**, хэлэлцүүлэгт аймаг, сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар оролцлоо.

Аймгийн 19 сумын ИТХ-ын дарга болон Нарийн бичгийн дарга нарын туршлага судлах, мэдлэг ур чадварын нэмэгдүүлэх уулзалт сургалт Өндөрхангай суманд 8 сард зохион байгуулж сумдын ИТХ-ын бодлого боловсруулах, Монгол улсын хууль, аймаг, сумын ИТХ-аас баталсан дүрэм журмын хэрэгжилтийг хангах, нутгийн захиргааны байгууллагууд, ИТХ-ын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хяналт үнэлгээний чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байгаа сумдын сайн туршлагыг судлан хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан мөрдөж байна.

Мөн Тайвань улсад Увс аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, ЗДТГ-ын дарга Г.Болор-Эрдэнэ нар "Монгол улсын Төрийн захиргааны албан хаагчдын гүнзгийрүүлсэн сургалт"-нд суралцаж ирээд орон нутагтаа Е-манлайллын эрэн үе, цахим засаглал гэсэн сэдвээр аймаг, сумдын ИТХ, ЗДТГ-ын дарга, эрхлэгч ажилчид болох 150 гаруй алба хаагчдыг хамруулсан үр дүнтэй сургалт зохион байгуулан ажиллав.





УИХ-ын тамгын газар, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, ШХА-ын санхүүжилтээр хэрэгжиж буй НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх төлийн хүрээнд баруун бүсийн аймгуудын НӨУЁБ-ын ажлын туршлага солилцох, хамтын ажиллагааг бэхжүүлэх уулзалтад 14 төлөөлөгч, ажлын албаны 5 ажилтан оролцож орон нутгийн бие даасан байдлыг дээшлүүлэх, орон нутгийн НӨУЁБ-ын эрхзүйн орчныг боловсронгуй болгох талаар санал солилцох, хэлэлцүүлэг зохион байгуулах ажилд идэвх санаачлага гарган оролцлоо. Тус хэлэлцүүлгээр НӨУБ-ын бүрэн эрхийг зөрчсөн, ЗЗНДНТУ-ын хууль болон Төсвийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болгуулах мөн бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх зарим асуудлын талаар 16 зүйл бүхий санал санаачлалыг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн зохион байгуулав.

**Аймгийн ИТХ-с зохион байгуулсан “АЯН” арга хэмжээ**

Аймгийн 90 жилийн ойн арга хэмжээтэй холбогдуулан аймгийн ИТХ-ын хороодоос ЗДТГ, иргэний танхим, Улаангом сумын ИТХ-тай хамтран “Авто зогсоол соёлтой үйлчилгээ, Өөрчлөлтийг өөрөө эхлээ, Сэтгэдэг сургууль-Бүтээдэг аймаг,





Ногоон байгууламж-ногоон хөгжил, Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” гэсэн 5 аяныг зохион байгуулсны үр дүнд тохижилт соёлжилтын ажил аймгийн хэмжээнд амжилттай явагдлаа.

### Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ аян

Увс аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг угтсан “ Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” аяны хүрээнд хийх тохижилтын ажлын талаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ:

- Төв номын сангийн арын хар зам дагуух 2 гудамжийг сонгон авч жишиг гудамж болгон тохижуулсан.
- Хогны менежментийг сайжруулахаар баг бүрээс 5 өрхийг сонгон авч 14 хоногийн хугацаанд тухайн өрхүүдийн хогийг нь ангилан ялгуулж судалгаа авсан.
- “Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.
- Хогны менежментийг сайжруулах талаар сургагч багшийг бэлтгэж, хар зам



дагуух нүүрний эгнээний нийт өрхийн 99% хашааны өнгө үзэмжээ сайжруулж, “Миний гэрээс манай хотын хөгжил эхэлнэ” аяны хүрээнд хашаандаа мод



тарих,ногоон байгууламж буй болгох хөдөлгөөн өрнүүлж шилдэг тохижилттой өрхөөр шалгарсан Раднаагийн Ядамсүрэн, Р.Баттулга, Ц.Алтансүх, Г.Тайван, Р.Баатаржав нарыг орон нутгийн телевизээр сурталчиллаа.

Хурлын төлөөлөгчид, ажлын алба, мэргэжлийн хяналтын газар, иргэний танхимтай хамтран “төвлөрсөн захуудын дэд бүтцийг шийдэх замаар орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн стандартыг хангах нь” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж 170 гаруй хүнийг хамруулж эрүүл цэвэр орчинд мах, сүү, ногоо, хүнсний бүтээгдэхүүн худалдах, “Улаангом менежмент” захад үйл ажиллагаа явуулдаг газруудыг халаалт болон цэвэр, бохирын шугамд холбох, орчны тохижилт, хогны асуудлыг шийдвэрлэхээр боллоо.

### “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” аян Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилийг хангаж ажиллав



Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье аяны хүрээнд аймгийн ИТХ онцгой анхаарч хог хаягдлын менежментийг сайжруулахаар олон тооны томоохон уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулан ажилласан. “Хог хаягдлын менежмент” иргэд олон нийтэд таниулах, сурталчлах сургагч багш бэлтгэх 2 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Эхний сургалт 03 сарын 02-нд боловсролын газрын сургалтын танхимд Улаангом сумын багийн дарга, нийгмийн ажилтан, идэвхтэн сонгуультан 20 хүн сургалтанд хамрагдсан. Төрийн албан хаагчдад мэдээлэл хүргэх сургалтыг 03 сарын 06-нд ЭМГ-ын сургалтын зааланд зохион байгуулж нийт 22 төрийн /сургууль цэцэрлэгээс бусад/ байгууллага хамрагдлаа. Сургалтыг 3 сэдвийн хүрээнд зохион байгуулсан. Үүнд:

1. Та хог үйлдвэрлэгч мөн үү?, хог хэзээ устдаг вэ?
2. Хог хаягдлын талаарх хууль эрх зүйн зохицуулалт,
3. Улаангом сумын хог хаягдлын менежмент, хог хаягдлын сан бүрдүүлэх тухай зэрэг агуулгаар мэдээлэл хүргэлээ.

Дээрх сургагч багшаар бэлтгэгдсэн 380 гаруй төрийн албан хаагчид нь амьдарч буй орчин тойрныхоо иргэд, оршин суугчдад сургалтаар олж авсан мэдээллээ түгээх, тэдэнд хог хаягдлын менежмент гэж юу болох, хор уршгийн талаар ойлголт, танилцуулга өгөх учиртай юм.





Мөн Аймгийн ИТХ-ын Хууль, эрхзүй дотоод хяналтын хорооны дарга Д.Нямсамбуу, Улаангом сумын ИТХ-ын дарга Б.Жавхлантөгс, Улаангом сумын Засаг дарга О.Ганхуяг нар Улаангом сумын эргэн тойронд үүсэн бүрэлдсэн, хур хог хаягдлын байр байдалтай газар дээр нь танилцаж, хэрхэх талаар ярилцлаа.

“Өөрчлөлтийг өөрөө эхлээ” аяны

хүрээнд хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар анхаарал тавьж ажилласнаар баруун бүсийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын үеэр Улаангом сумын Засаг дарга, Улаанбаатар хотын Элемент ХХК хамтран ажиллах гэрээ байгуулж хаягдлыг боловсруулах үйлдвэр байгуулахаар боллоо.

. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох “ӨӨРЧЛӨЛТИЙН ӨӨРӨӨСӨӨ ЭХЛЭЭ” хөдөлгөөн, “МИНИЙ ГЭРЭЭС МАНАЙ АЙМГИЙН ХӨГЖИЛ ЭХЭЛНЭ” аяны

танилцуулга, мэдээлэл хийх иргэд олон нийтийн хэлэлцүүлэг уулзалт 2015 оны 05 сарын 20-ны өдөр “Ойрад” ХДТ-т зохион байгууллаа.

1. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлээ” хөдөлөөний танилцуулга – Ч.Чимэд, Аймгийн ИТХ-ын дарга
2. Улаангом сумын хур хогны одоогийн байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээ - С.Буяндалай, Байгаль орчны улсын байцаагч
3. Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний төлөвлөгөө - Б.Гомбосүрэн, Улаангом сумын орлогч дарга
4. Хогны менежментийг боловсронгуй болгох арга туршлага, хог боловсруулах үйлдвэр - Баярсайхан, Элемент ХХК-ны захирал
5. “Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” аяны зорилго, танилцуулга - Г.Болор-Эрдэнэ, ЗДТГ-ын дарга
6. “Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” болзолт уралдааны танилцуулга - Жавхлантөгс, Улаангом



сумын ИТХ-ын дарга нар танилцуулга хийлээ.

Уулзалтад Улаангом сумын нийт 150 гаруй ард иргэд хүрэлцэн ирж санал бодлоо солилцож 2000 төгрөгний хогны хураамжны талаар нэгдсэн ойлголтод хүрлээ. Мөн хэлэлцүүлэгт ирсэн иргэдээс “Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад иргэдийн хандлага ямар төвшинд байгааг тодорхойлох”, “Хүнсний захын эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл байдлын талаарх” гэсэн 2 судалгааг авлаа.



### Зохион байгуулсан хэлэлцүүлэг

#### **Төвлөрсөн хүнс барааны захуудын дэд бүтцийг сайжруулах замаар, орчин нөхцийг сайжруулах нь ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

Хэлэлцүүлгийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба, Мэргэжлийн хяналтын газар, Иргэний танхимтай хамтран “Төвлөрсөн захуудын дэд бүтцийг шийдэх замаар орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн стандартыг хангах нь” сэдвээр 2015.05.04-ний өдрийн 09:00 цагт “Иргэдийн оролцоо” танхимд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт “Улаангом менежмент” захын төлөөлөл, тус захад үйл ажиллагаа явуулдаг худалдаа эрхлэгчид оролцов.

Хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-ийн “Иргэний оролцоо” хурлын танхимд 2015 оны 5-р сарын 04-нд 14:00 цагаас зохион байгуулагдав. Хэлэлцүүлэгт Увс ХК ны хүнсний захад худалдаа эрхлэгчид, Захын эзэд нийт 75 хүн оролцов.

Хэлэлцүүлгийг хүнсний захын байрлал, худалдаа эрхлэгчдийн төлөв байдлаас хамааруулан Улаангом менежмент захын удирдлага, энэ зах дээр үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа эрхлэгчид, гуанз цайны газар ажиллуулж байгаа бизнес эрхлэгчдийн нэг хэсэг, Увс ХК-ны зах дээр үйл ажиллагаа явуулж байгаа Мах, Сүү, Ногоо, Хүнсний бүтээгдэхүүний худалдаалж байгаа бизнес эрхлэгчдийн нэг хэсэг болгон 2 тусдаа зохион байгуулав

*Хэлэлцүүлэгт оролцож иргэн, аж ахуйн нэгжийн саналыг сонссоны дүнд дараах шийдэлд хүрэв.*

1. Хөгжлийн бодлогын хэлтэс хариуцан мэргэжлийн байгууллагуудын оролцуулсан ажлын хэсэг гаргаж, шугам сүлжээнд холбогдох трассыг 5-р сарын 11-ний дотор гаргаж өгөх.
2. Шугамын холболтоо иргэн, аж ахуйн нэгжүүд Улаангом менежмент компанийн тохижилтыг ажил эхлэхээс өмнө хийж дуусгах.
3. Захад баригдах нийтийн бие засах газрыг шийдэх өгөх.
4. Улаангом менежмент компани хогны асуудлыг шийдэх. Хэлэлцүүлгийн үеэр гарсан өдөр бүр хог ачих гэрээт ажилчинтай болох асуудлыг судлаж шийдвэрлэх.

Улаангом менежмент компани тохижилтын ажил хийхдээ мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөө авах, эрсдэлийг тооцох.

***“Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд өөрчлөлт оруулах санал авах” хэлэлцүүлэг***



Хэлэлцүүлэг 2015 оны 9-р сарын 15-ны өдрийн 15.00 цагт аймгийн ИТХ-ын “Иргэдийн оролцоо” танхимд явагдлаа. Хэлэлцүүлэгт аймгийн ИТХ-ын төлөөлөгч З.Алтансүх, С.Баяржаргал, Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч Р.Рагчаасүрэн, Ү.Уламбаяр, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга З.Ганболд, Ч.Энхбаяр, Г.Батмөнх, аймгийн ҮЭХ-ны хуулийн зөвлөх Д.Энхтуяа, аймгийн сум дундын анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч Л.Алтан, Түргэн сумын Засаг дарга Э.Бямбаа, Наранбулаг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Орсоо нарын 14 хүн оролцов.

Хэлэлцүүлгийг нээж аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд мэдээлэл хийлээ.

Баян-Өлгий аймагт болсон баруун 5 аймгийн НӨУБ-ын сонгуультан, ажилтнуудын семинараар ЗЗНДН, түүний удирдлагын тухай хуулинд өөрчлөлт оруулах төсөлд санал авах хэлэлцүүлэг өрнүүлж хуулийн төсөл дээр ажиллаж байгаа зөвлөхүүд мэдээлэл хийсэн. Хуулийн төслийг УИХ-ын гишүүн А.Бакей, Батчимэг, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ганзориг нар санаачлан боловсруулсан. Энэ семинарийн үеэр аймгууд тус бүртээ мөн хэлэлцүүлэг зохион байгуулж хуулинд оруулах өөрчлөлтөөр санал авах хэлэлцүүлэг явуулж саналыг нэгтгэж УИХ-ын төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын хэсэгт хүргүүлэх үүрэг авсны дагуу энэ хэлэлцүүлгийг явуулав. Энэ хуулийг өөрчлөх тухай өнгөрсөн жил МНУХ-оос өргөн хэлэлцүүлэг хийж аймаг, сумын ИТХ-уудын саналыг авч нэгтгэн УИХ-д хүргүүлсэн байгаа. Хэлэлцүүлгээр дараах саналууд гарлаа.





- Хуулийн нэр томъёоны тайлбарыг хуулийн эхэнд нь хийж өгөх хэрэгтэй. Хуулийг хөдөө орон нутагт хэрэглэхэд тэр бүр хуульч хүрэлцэхгүй тул хуулийг хэрэгжүүлэхэд дөхөмтэй болгож нэр томъёоны тайлбарыг гаргах хэрэгтэй.
- Энэ хуульд нийцүүлэх зайлшгүй шаардлагатай хуулиудад давхар өөрчлөлт оруулах хэлэлцүүлгийг хийх хэрэгтэй
- ЗЗНДН, түүний удирдлагын тухай хууль нь орон нутгийн хувьд хамгийн гол тулгуур хууль учраас ингэж хэлэлцүүлэг хийж нухацтай ярилцаж саналаа өгч байгаа байх. Энэ хуультай нийцэх хуулиудад орох өөрчлөлтийг яаралтай хийх хэрэгтэй.
- Бусад хуулиар зохицуулагдсан заалтуудыг тодруулах хэрэгтэй.
- Улс төрийн намын харьяалалгүй болох нь хамгийн ойлгомжгүй байна. /Давуу болон сул талуудыг харах хэрэгтэй / Бүлгийн үйл ажиллагаа байхгүй болно.
- Улс төрийн намын харьяалалгүй болгоно гэсэн энэ заалт нь Улс төрийн намуудын тухай хуулинд давхар өөрчлөлт оруулж шийдэх шаардлагатай гэж үзэж байна. Намгүй болсноор төлөөллийн зарчим алдагдана гэж үзэж байна
- Баг хорооны ИНХ, аймаг сумын ИТХ-ын төлөөлөгч, дарга нарын төрийн тусгай болон ТЗ албан хаагчид шиг өндөр шаардлага тавих нь буруу юм.
- Орон нутагт эрх мэдэл хэт их төвлөрүүлэх нь эрсдэл ихтэйг анхаарч үзэж хэрэгтэй.
- Тулгуур зарчим хэн нэгнийг ахмад настай гэдгийг хасах, улс төрийн намын харьяалалгүй гэдгийг УИХ-аар өнөөдөр шийдээгүй байхад ярьж байна. Сонгох сонгогдох эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүлгийн үйл ажиллагаа алга болсон байна.
- Аймгийн ЗД-ийн эрх үүргүүд ерөнхий тусгагдсан байдаг үүнийг илүү нарийвчлах хэрэгтэй.
- ЗДТГ нь ямар чиг үүрэгтэй байхыг мөн нарийвчлан зааж өгөх хэрэгтэй байна. Жишээ нь ХЗХ –нь ямар чиг үүргээр ажиллах вэ гэдгийг маш тодорхой болгох
- Хуулийн нэр томъёоны тайлбарыг сайн оруулж өгөх шаардлагатай
- Аймгийн төвийг хотын статустай болгохыг тусгай хуулиар шийдвэрлэх нь зүйтэй ч энэ хуулинд бас тусгаж өгөх нь зөв.



- Багийн хилийн цэсийг тодорхой болгож батлах нь зүйтэй. Учир нь өнөөдөр хүн ам олноор суурьшсан газар нутагт багийн хилийн маргаан их гардаг үүнийг тодорхой болгох шаардлагатай.
- Баг бие даасан төсөвтэй байхыг 6.1-д нэмж тусгах. Нутаг дэвсгэрийн хэмжээ хүн амын тоотой уялдуулан төлөвлөх нь зүйтэй.
- 38.2-д төрийн албанд ажилласан жилийг яг 25 гэж ялгаатай заахгүй байх. Яагаад гэвэл орон нутгийн төвшинд энэхүү нөхцөлд жил нь хүрдэггүйгээс тухайн мөнгө тусламжаа авч чаддаггүй тохиолдлууд гарсаар байна. Иймд төрийн албанд биш улсад ажилласан жилээр нь юмуу эсвэл тодорхой жил заахгүйгээр олгох саналтай байна.
- 38.6-г өөрчилж Баг, хорооны хурлын дарга нарыг албажуулж цалинтай шатанд оруулж явбал энэхүү албан тушаалтнуудыг хариуцлагажуулахад чөлөөтэй болно. Тэгэхгүй бол зүгээр л сул “ард” явсаар байна.

### Цахим засаглал нэвтрүүлэв

Мэдээлэл технологийн хөгжлийн шинэ нөхцөлд ажиллах шаардлагыг харгалзан “Цахим–Увс” хөтөлбөрийг 2010 онд аймгийн ИТХ-аас баталж хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн ИТХурал манлайлан оролцож цахим засаглалын хүрээнд аймаг, нийслэлийн хурлуудын дунд анх удаа ухаалаг утас, таблет ашиглан иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны цаг бүртгэл, санал бүртгэл, санал хураалт, асуулт асуулга тавих гэсэн 4 горимтой хуралдааныг удирдах, цахим мэдээлэл танилцуулгыг лед дэлгэцээр харуулдаг удирдлагын цогц системийг нэвтрүүлээ

2015.11.25 Хяргасын 0,5 га нөхөн сэргээлт явуулахыг дэмжих	
Зөвшөөрсөн	1 (5%)
Татгалзсан	18 (95%)
НИЙТ	19

Ирц: 28/4 Санал хураалтын дүн

2015.11.25 2016 онд газар зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай	
Зөвшөөрсөн	25 (96%)
Татгалзсан	1 (4%)
НИЙТ	26

Ирц: 29/4 Санал хураалтын дүн


Сумдын хурал, төлөөлөгч бүрт бүх төрлийн мэдээ мэдээлэл солилцох албан Е-мэйл хаяг, техник хангамжтай болж, төрийн байгууллагуудын удирдлагын нэгдсэн цахим системд холбогдож хурлын байгууллагын мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэх нөхцөлийг бүрдүүлснээр төлөөлөгч бүр хурлаар хэлэлцэх материалыг цахим хэлбэрээр авч, мэдээ тайлангаа тогтсон сувгаар ирүүлэх, цаасны хэрэглээг бууруулж цахим мэдээллийг байнга ашиглаж хэвшлээ.

Аймгийн НӨУБайгууллагуудын мэдээ мэдээллийн шуурхай байдлыг хангах, цаасгүй мэдээллийг нэвтрүүлэх зорилтын хүрээнд аймаг, сумын ИТХ-аас хийсэн ажлын онцлох мэдээг сар бүрийн “Онцлох мэдээ”-нд тусгуулж мэдээллийн нэгдсэн

сан үүсгэж, сумдын ИТХ, аймгийн төлөөлөгчид, тэргүүлэгчид болон албан газруудад цахим хэлбэрээр цаг тухайд нь хүргэж ажиллав.

Сошиал медиа сувгаар мэдээлэл түгээх зорилтын хүрээнд Аймгийн ИТХ-ын ажлын албанаас ёсны вэб сайт <http://.uvs.khural.mn>, веб сайтыг боловсронгуй болгож мэдээл мэдээлэл, ИТХ-аас гарсан тогтоол шийдвэр, ОНӨмчийн дуудлага худалдааны зар мэдээлэл, бусад чиглэлийн мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэдэд ойлгомжтой энгийн байдлаар түгээхэд анхаарч веб сайтыг бүрэн шинэчилж хандалтыг тоог 125,000-д хүргэж ажиллав. Мөн Фэйсбүүкт <https://www.facebook.com/uvskhural> Увс аймгийн Хурал гэсэн хаяг, Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэсэн page хуудсаар дамжуулан нэг дор 5000 гаруй хүнд мэдээлэл түгээж байна.

НӨУБ-ын чадавхийг бэхжүүлэх төслөөс 21 аймгийн ИТХ-ын дунд зарласан ИТХ-ын дэд цахим хуудас хөгжүүлэх болзолт уралдаанд шалгарч 1 сая төгрөгөөр шагнууллаа.



Төрийн байгууллагын удирдлага мэдээллийн цогц систем систем <http://intranet.gov.mn> –ийн ашиглалтыг сайжруулснаар албан бичиг, цаг бүртгэл, ажлаа төлөвлөхөд ашиглан албан ажлын мэдээллийг түргэн шуурхай солилцон ажиллах, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулсан алхмыг бүрдүүлсэн.

### Хурлын төсвийн зарцуулалт:

Аймгийн ИТХурал, ажлын алба 2015 онд 11 орон тоотойгоор 294.1 сая төгрөгийн төсөв, төлөөлөгчдийн үйл ажиллагааны 61.5 сая нийт 355,6 сая төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үүнээс тодотголоор 7,814 сая төг хасагдаж 35.6% нь ажлын албаны ажилчдын цалин урамшуулалд, 3,9% НДШимтгэлд, 5,6% нь дотоод болон гадаад томиллод, 5% нь тээвэр шатахууны зардалд, 1,3% нь бичиг хэрэгт, 1,3% нь шуудан холбоонд,

3,4% нь хуралдааны зардалд, 3,6% нь намын суудалд 1,9% нь мэдээлэл сурталчилгаанд, 5,5% нь нэг удаагийн зардалд, 6,4% нь ГХУСАЗЗөвлөлийн, 1,6% нь цагаатгалын комиссын ажилд, 1,1% нь ном хэвлэлд, 0,9% нь эд хогшил худалдан авахад, 3,8% урсгал засварын зардалд, 1,8% нь төлбөр хураамжийн зардалд, 17,3% нь төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардалд тус бүр 285,1 сая төг нь үйл ажиллагааны дагуу зарцуулагдсан байна. Үлдсэн 64,7 сая төгрөгийн санхүүжилт нь тавигдаагүй учраас өр төлбөртэй гарсан.

Нэмэлт санхүүжилтээр “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавх”-ыг бэхжүүлэх нь төслөөр 26,7 сая төгрөгийн санхүүжилт бүхий сургалт зохион байгуулсан.

## 2015 оны зардлын зарцуулалт

Зардлын зүйл	Зарцуулах эрх	Төсвийн гүйцэтгэл
Үндсэн цалин	126,543,400	126,542,421
НДШ	13,919,500	13,919,500
Бичиг хэрэг	4,800,000	2,907,550
Тээвэр шатахуун	51,000,000	26,827,592
Шуудан холбоо	4,500,000	4,584,699
Дотоод албан томилолт	22,873,000	31,166,650
Гадаад томилолт	25,730,400	12,110,220
Ном хэвлэл худалдан авах зардал	3,500,000	1,355,500
Хичээл үйлдвэрлэл дадлага		20212000
Төлбөр хураамж	9,601,500	6,952,400
Бараа үйлчилгээний бусад зардал	49,580,600	30,485,467
Нэг удаа, тэтгэмж урамшуулал	22,933,200	22,915,300
Багаж техник, хэрэгсэл	3,200,000	3,200,000
<b>Нийт орлого</b>	<b>348,192,100</b>	<b>381,467,200</b>
<b>Урсгал санхүүжилт</b>		<b>348,192,100</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>28,700,00</b>
<b>Нийт өглөг</b>		<b>65,215,164</b>

## Сумдын ИТХ-ын ажлын талаар:

Аймгийн 19 сумдын ИТХ-ын хуралдаан 41 удаа хуралдаж 235 асуудал хэлэлцэж 788 заалт бүхий 240 тогтоол гаргаж, 14 дэд хөтөлбөр, төлөвлөгөө баталсан байна.

Тэргүүлэгчдийн хурал 230 удаа хуралдаж, 824 асуудал хэлэлцэж 1970 заалт бүхий 823 тогтоол, 15 журам гарган хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Хурлын хороод 50 удаа хуралдаж, 46 санал дүгнэлт гаргаж, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажил, үйлчилгээ, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хэрэгжилт зэрэгт 244 удаа хяналт шалгалт хийж 596 хүн хамрагдаж 25 зөвлөмж өгч ажилласан байна.

Багийн ИНХ бүр 1-2 удаа буюу 248 удаа хуралдаж 9337 иргэн оролцож 171 асуудал хэлэлцэж Иргэдийн дунд 129 хэлэлцүүлэг, 40 санал асуулга явуулж 5188 иргэн оролцож 845 санал гаргаснаас 544 саналыг захирамж, тогтоол, тушаалд тусгаж 171 саналыг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилжээ.

Хяргас сумын ахлах 90 жилийн ойн арга хэмжээний хүрээнд ахмад багш Д.Батаагийн нэрэмжит Математикийн олимпиадыг зүүн 9 сумын сурагчдын дунд, Баруунтуруун сумын ИТХ-аас “Радио телевизийн сүлжээ” улсын үйлдвэрийн газрын хөрөнгөөр дахин дамжуулах шинэ станцыг бариулж Зүүнтуруун, “Баян-Айраг” багийн иргэд, малчдыг 16 суваг, радио FM сонсох сүлжээгээр хангасан үр дүнтэй ажлыг зохион байгуулан ажиллажээ.

Зүүнхангай сумын ИТХ бүх нийтийн боловсролыг 2015–2020 онд хөгжүүлэх дэд хөтөлбөр, Сагил сумын ИТХ сумын хөгжлийн 2015-2030 оны хөтөлбөр хэлэлцэн баталлаа.

Өндөрхангай сум ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж байгаа цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлын явцад ОНХС-ийн зөвлөл, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд Төсөв, санхүү, эдийн засгийн Хороо тус тус хяналт хийж, хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, бүтээгдэхүүн нийлүүлж байгаа аж ахуйн нэгж, газруудыг шалгаж зөвлөмж өгч байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон ЗДТГ-ын хамтарсан хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсэг 18 суманд ажиллаж хууль, ЗГ-ын тогтоол шийдвэр, аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, сумын ИТХ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт үнэлгээ хийж, сумын ИТХ-аас иргэд, олон нийтийн байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, зөвлөмж өглөө.

2014 оны сумдын ИТХ-ын ажлын дүнг үндэслэж аймгийн шилдэг сумын ИТХ-ын дарга 3, хурлын нарийн бичгийн дарга 3, иргэний танхимын ажилтан 3, Хурлын ажлын албаны шилдэг ажилтан нэг, аймгийн тэргүүний багийн ИНХ нэгийг тус тус шалгаруулж аймгийн ИТХ-ын Хүндэт медальон, дурсгалын зүйлээр шагнаан урамшууллаа.

### Мэдээлэл сурталчилгаа

2015 оны аймаг, сумын ИТХ-ын онцлог шинэ ажлаар ширээний календарь хэвлүүлж, бичмэл сэтгүүлийн 4 дугаар, онцлох мэдээний 12 дугаар тус тус бэлтгэн гаргаж, ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалтын гарын авлагыг аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сумдын ИТХ, бусад холбогдох байгууллагуудад хүргүүлж мэдээллээр хангаж ажиллалаа.

Орон нутгийн МВС, САМА телевизүүд, “Увсын өнгө” сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласнаар аймгийн ИТХ-ын хийж хэрэгжүүлсэн ажлаа мэдээлэн сурталчилж, 3 төлөөлөгч сонины нүүр гаргаж, 8 төлөөлөгчид “Төлөөлөгчийн нэрэмжит өдөрлөг” зохион байгуулж, “Нутгийн удирдлага” сэтгүүлд



аймгийн ИТХ, Давст, Малчин, Завхан сумууд мэдээлэл, туршлагаа нийтлүүлж сурталчилсан.

Аймгийн ИТХ-ын 22 төлөөлөгчид “Увс аймаг дахь ардчилсан засаглалын 1000 өдөр” аянаар 19 суманд ажиллаж болон мөн төлөөлөх үүргээ хэрэгжүүлэн тойргийнхоо иргэдтэй уулзалт, ярилцлага хийж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажиллалаа.

Мэдээллийн нэгдсэн бааз үүсгэх, мэдээллийн нэгдсэн сантай болох үүднээс аймгийн ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлын 2012-2014 оныг хүртэл хугацаанд гаргасан тогтоол, төрийн дээд одон медальд шагнагдсан хүмүүсийн судалгааг нэгтгэсэн мэдээллийн сан үүсгэлээ.

## ХОЁР. ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААН

### Аймгийн ИТХ-ын 9-р хуралдаанаар :

Аймгийн ИТХ-ын хуралдаан 2 удаа 81,5% -ийн ирцтэй хуралдаж 12 асуудал хэлэлцэж 74 заалт бүхий 14 тогтоол, 3 тэмдэглэл гаргаж, давхардсан тоогоор 97 төлөөлөгчид 322 санал шүүмжлэл гаргаснаас 59 санал хурлын шийдвэрт тусгаж бусад 65 санал шүүмжлэлүүдийг холбогдох байгууллагуудын зорилт, ажлын төлөвлөгөөнд тусгуулахаар хүргүүлээ.



### **2015 оны 3-р сарын 30-нд хуралдсан 9-р хуралдаанаар**

- 2024 онд их наядын ДНБ-тай аймаг болох зорилт дэвшүүлж “Их наяд-Увс 2024” хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө,
- Бөхмөрөн, Сагил сумдын 215995 га газрыг “Гулзат” нэрээр 5 жилийн хугацаатай ОНХГ-д авч, хилийн цэс, түүний агнуурын бүсийн хил, орон

нутгийн хамгаалалттай газрын /Гулзат/ 2015-2019 оны менежментийн төлөвлөгөө, агнуурын бүсийн 2015-2016 оны менежментийн төлөвлөгөө, 2015-2025 оны стратеги төлөвлөгөө,

- Дулааны 1, 2-р станцын шугам сүлжээнд нам даралтын зуух, хэрэглэгчдийг холбох, дулааны халаалтын үнийг уян хатан тогтоож орчны болон агаарын бохирдлыг бууруулах гэсэн асуудлуудыг хэлэлцэн баталж хэрэгжилтийг холбогдох байгууллага, албан тушаалтан зохион байгуулан ажиллаж байна.
- 2015 оны төсвийн тодотголыг хэлэлцэн батлав

Аймгийн ИТХ газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, газрын нэгдсэн сангийн тайлан батлах, газрын кадастрын мэдээллийн сангийн программыг нэвтрүүлэх, хилийн цэсийн эргэлтийн цэг батлах тухай тогтоол шийдвэр гаргаж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, доройтсон газрыг нөхөн сэргээх, шинэ суурьшлын бүс тогтоох, орон сууцжуулах хөтөлбөр, ашиглалтгүй байгаа газрыг хураан авч дахин хувиарлах, газрын шинэтгэлийн бодлого, газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зэрэг бодлого барьж газар зохион байгуулалтыг боловсронгуй болгон доройтолд орсон 362 га газрыг нөхөн сэргээж, хамгаалалтад авч, орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 9,8 га-д газарт 646 айлын орон сууц ашиглалтад орсон байна.

Хууль бус газар олголтоор олгосон газрын хураан авч дахин хуваарилах бодлогоор аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан Улаангом суманд 400 айлын жишиг хороолол төлөвлөн 101 иргэнд 7.07 га газар олгосон.

Аймгийн хэмжээнд 2013-2015 онд барилга байгууламжийн зориулалтаар 166.3 га, аялал жуулчлалын зориулалтаар 15.8 га, гэр хашааны зориулалтаар 74.1 га, төмс хүнсний ногоо, жимс, жимсгэний зориулалтаар 203.4 га, хадлангийн зориулалтаар 2656.5 га, зам шугам сүлжээний зориулалтаар 399.2 га, ашигт малтмал олборлох зориулалтаар 1052 га газар тус тус эзэмшүүлсэн.

#### Аймгийн ИТХ-ын 10-р хуралдаанаар :

- Аймгийн ИТХ-ын 2015 оны ажлын үр дүн, цаашдын зорилтын тухай хэлэлцээд аймгийн ИТХ-ыг “Хангалттай” ажилласан гэж дүгнэлээ.
- Газрын шинэтгэл, 2016 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Аймгийн 2015 оны төсвийн тодотгол, 2016 оны төсөв,
- аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн болон 2015 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтын биелэлт, 2016 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтыг баталлаа.
- Багийн талаар авах арга хэмжээний тухай Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны А/124 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан олон удаагийн ажил, уулзалт хэлэлцүүлгээр гарсан саналууд, багийн өрх, хүн амын судалгаа, тооцоо, багаас иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар,

хүртээмжийг сайжруулах зайлшгүй шаардлагыг үндэслэн өөр сумын нутаг дэвсгэр дээр олон жил амьдарч байгаа иргэдийг тухайн сум, багт шилжүүлж, Тариалан сумын Толь багийг татан буулгаж, Улаангом суманд нэг баг шинээр нэмж байгуулахаар шийдвэрлэлээ

Хуралдаанаар аймгийн засаг даргын 2013-2016 оны мөрийн хөтөлбөр 85,5%, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх 2015 оны зорилтын 90,7% биелэлттэй гэж дүгнэв.

Монгол улсын хэмжээнд Увс аймаг газар төлөвлөлт, зохион байгуулалтын land менежер цахим системийг нэвтрүүлээ.

## ГУРАВ. ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал нийт 16 удаа хуралдаж 83 асуудал хэлэлцэж, 202 заалт бүхий 75 тогтоол, 23 тэмдэглэл гаргаж, төлөвлөгөөт биелэлт 96 хувьтай байна.

Тогтоолын ангилал	Тоо
Журам батлах	4
Төсөв хэлэлцэх	3
Хөтөлбөр төсөл батлах	7
ОНӨмчтэй холбоотой	22
Ажлын тайлан хэлэлцэх, үнэлгээ өгөх	12
Тогтоол шийдвэрийн хэрэгжилт	1
Төрийн дээд шагналт тодорхойлох	12
Гэмт хэргийн эсрэг ҮА, дэг дурам сахиулах	1
Нийгэм эдийн засгийн, цаг үеийн тулгамдсан асуудал	2
Гудамж талбайд нэр өгөх, нэрэмжит болгох	1

### Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан хөтөлбөр төлөвлөгөө

- Мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө,
- жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үндсэн чиглэл,



### Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан дүрэм журам

- Увс нуурын дэргэдэх аялал жуулчлалын гэр баазыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээ, сонгон шалгаруулалтын журам,
- ИТХ-ын хяналт үнэлгээний журам,
- Хог хаягдлын болон мал эмнэлгийн үйлчилгээний төлбөр хураамж,
- Согтууруулах ундаа түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэх,
- Хөндөгдсөн газарт нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгж, нөхөрлөлийг сонгон шалгаруулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих журамд өөрчлөлт оруулах,

### Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан ОНӨААТҮГ

- Малчин суманд ойн анги байгуулах,
- Аймгийн төвийн дулаан халаалт, шугам сүлжээний үйл ажиллагааг эрхлэх “Дулааны 2-р стандарт” ОНӨААТҮГ газар байгуулах
- Тэс сумын нэгдсэн халаалт, цэвэр бохир усны системийн үйл ажиллагааг хариуцах “Таван тэсийн Илч” ОНӨААТҮГ газар байгуулах, түүний ажиллах журам, хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, татварын орлогын бүрдүүлэлт, Мини захын менежментийн гэрээний биелэлтэнд дүгнэлт хийх,
- “Шинэ Улаангом” ОНӨААТҮГ-ын тайлан, сүм хийдүүдэд зөвшөөрөл олгох зэрэг асуудлыг хэлэлцэн баталлаа.

Эдийн засгийн бодлогын хүрээнд Татварын бааз суурийг нэмэгдүүлэх идэвх санаачлага гарган 2015 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг Сангийн яамнаас 5329.8 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн бөгөөд Аймгийн ИТХ-ын хуралдаанаас татварын орлогыг 6173,9 сая төгрөг болгон батлаж татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх талаар татварын орлогыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж буй 11 байгууллагуудад тодорхой үүрэг даалгавар чиглэл өгч ажилласны үр дүнд үл хөдлөх хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, газрын



төлбөр, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн татвар зэрэг нэр төрлийн татварын орлого нэмэгдсэн байна.



Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн саналыг хэлэлцээд Хөдөлмөрийн баатар цол 2, Гавьяат зүтгэлтэн 26, Сүхбаатарын одон 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 33, Алтан гадас одонгоор 184, Цэргийн гавьяаны улаан тугийн одон 3, Цэргийн гавьяаны одон 3, Цэргийн хүндэт медалиар 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 226 хүнийг шагнуулахаар Ерөнхийлөгчид уламжилж, материалыг ЕТГазарт хүргүүлсэн.

Үүнээс Хөдөлмөрийн Гавьяаны улаан тугийн одонгоор 23, Алтан гадас одонгоор 150, Цэргийн гавьяаны одон 4, Хөдөлмөрийн хүндэт медаль 83, Цэргийн хүндэт медалиар 3 хүн, “Алдарт эх-1” одонгоор 47, “Алдарт эх-2” одонгоор 306 эх, аймгийн ИТХ-ын “Хүндэт өргөмжлөл” –өөр 49, Баярын бичгээр 8 хүнийг тус тус шагнагдсан байна.

### Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэлт

2015 онд Аудитын тайлан 18, албан тоот 4, Засгийн газрын тоот 14, ЗГ-ын тогтоол 17, ЗГ-ын тэмдэглэл 7, ЗГ-ын захирамж 2, УИХ-ын албан тоот 8, сум байгууллага, агентлаг, хэлтэс, төрийн бус байгууллагын албан тоот 137, Засаг дарга ЗДТГ-ын тэмдэглэл 10, Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан тоот 2, Авилгатай тэмцэх газрын тоот 13, Сонгуулийн ерөнхий хорооны албан тоот 1, ЦАУЗБУКомиссын албан тоот 8, сумдын хурлаас 33, Цагдаагийн хэлтэс 13, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөс 6, ГХУСАСЗ-ийн гишүүн байгууллагаас 22, иргэний өргөдөл 12, НӨУБайгууллагаас 5, нийт 336 албан тоотыг хүлээн авч судлан шийдвэрлэлээ.

Аймгийн ИТХ-ын хороод 9 удаа хуралдаж, 7 санал дүгнэлт гаргаж ажилласан байна. Мөн аймгийн түүхт 90 жилийн ойн ажлыг угтаж аймгийн

хэмжээнд хороо тус бүр 5 бүтээлч аяныг зохион байгуулалтаар ханган ажиллаа. Эдгээр аяныг иргэд байгууллагуудын оролцоонд тулгуурлан амжилтай зохион байгуулсан ажлын үр дүнг нэгтгэн танилцууля.

Салбар хэлтэс	Бүгд	Хуудас	Хариугай				Хариугүй		Байгууллаг ад эзлэх хувь	
			Нийт	Шийдвэрлэсэн	Шийдвэрлэлтийн хувь	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн	Нийт		Шийдвэрлэсэн
Удирдах ажилтнууд	282	1091	36	32	88.89%	0	4	246	212	84.18%
Ажлын алба	52	189	3	3	100%	0	0	295	46	15.52%
ИТХ-ын тэргүүлэгчид (Тэргүүлэгч)	0	0	0	0	0	0	0	295	0	0
Хурлын төлөөлөгчид	0	0	0	0	0	0	0	295	0	0
Бусад байгууллагын хяналтанд байгаа бичгүүд	0	0	0	0	0	0	0	295	0	0
<b>Бүгд</b>	<b>334</b>	<b>1280</b>	<b>39</b>	<b>35</b>	<b>89.74%</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>295</b>	<b>258</b>	<b>100%</b>

### ИТХ-ын хорооны үйл ажиллагаа

#### Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хороо:

“Миний гэрээс манай аймгийн хөгжил эхэлнэ” аяны хүрээнд Улаангом суманд болзолт уралдаан өрнүүлж гудамж төслийн хүрээнд хар зам дагуух айл өрхүүдийн хашаа, гудамжийг өртгөтгөн засаж тохижуулжээ.

#### Хууль эрх зүй дотоод хяналтын хороо:

Тус хорооноос Увс аймгийн нутаг дэвсгэрт хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай санаачлалыг гарган тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулав. “Өөрчлөлтийг өөрөө эхлэе” аяны хүрээнд хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сум байгууллага айл өрхүүдийн орчны тохижилтыг сайжруулах зэрэг аяныг аймгийн хэмжээнд зохин байгуулж 19 сумын хэмжээнд хур хогтой газрын тархац 334 га газар байснаас , 190 га газрыг цэвэрлэж, 182 байгууллага, аж ахуйн нэгж 5917 м<sup>2</sup>, 5754 айл өрхөөс 404453м<sup>2</sup> газарт хашаа, байшингийн тохижилт өнгө үзэмжийг засаж сайжруулсан байна.

#### Төсөв санхүү эдийн засгийн хөгжлийн хороо:

Авто зогсоол соёлтой үйлчилгээ уриалгын хүрээнд 1 удаа хуралдаж, хяналт шалгалт явуулах, судалгаа хийж санал дүгнэлт гаргах, баримт бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах ажил зохион байгуулж энэ ажилд төлөөлөгчдөө татан

оролцуулж ажиллав.Авто зогсоол соёлтой үйлчилгээ аяны хүрээнд аймгийн хэмжээнд 2777,4 м<sup>2</sup> бетон хучилттай авто зогсоол, 939 м<sup>2</sup> шороон хучилттай зам, 2535 м урт явган хүний зам хийгдсэн байна.

Хүний хөгжил нийгмийн асуудал эрхэлсэн хороо:

2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан “Сэтгэдэг сургууль Бүтээдэг аймаг” аяны хүрээнд ЕБСургуулиудад Нэг анги-1000 бодлого, Дотуур байр-Миний гэр, Нэг сурагч-Нэг бүтээл хөдөлгөөн өрнүүлж аймгийн хэмжээнд цаасан урлал, эсгий бүтээл хийх, “Хаягдал материал ашиглан хувцас” зохион бүтээх уралдаан зохион байгуулж аймгийн хэмжээнд 19 сумын сурагчид 10640 орчим бүтээл урлан, 267,2 мянган бодлого бодож сурагчдын бүтээлч сэтгэлгээ, сэтгэн бодох чадварыг хөгжүүлж ажилласан байна.

Байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлын хороо:

Ногоон байгууламж, ногоон хөгжил аяны хүрээнд аймгийн хэмжээнд албан байгууллага, ард иргэд нийт шинээр 20550 м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт, 10804 ширхэг мод цэцгийн мандал 1400м<sup>2</sup> талбайд тарьж, 16487 м<sup>2</sup> талбайд арчлалт хамгаалалт, хашлага хийсэн байна.

## ДЭРӨВ: ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР

Орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн сангийн ашиглалтыг сайжруулах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг цаг тухай бүр бүртгэн тайлагнах, ялангуяа Улаангом сумын төсөвт байгууллагуудын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах, хөрөнгийн үнэлгээг сайжруулахад анхаарч аймгийн ИТХ-ын ажлын албаны 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгуулан ажлын албаны даргын удирдамж боловсруулан ажиллав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас 267.2 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, 105.3 сая төгрөгийн хөрөнгийг актлах, 1295.6 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 26.7 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргаж байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн асуудлуудыг хууль журмын дагуу бүрэн шийдвэрлүүлж ажилласан.

Орон нутгийн өмчийн түрээсийн орлогоос 12.9 сая, Орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалтгүй хөрөнгийг худалдан борлуулсны 135.0 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй ажилласнаас 191.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 142.0% -иар давуулан биелүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн хөрөнгийн дуудлага худалдааг 12 удаа нээлттэй зарлан, хууль журмын дагуу зохион байгуулж ажилласан.

Орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ажлын байр бий болгох зорилгоор иргэд аж ахуйн нэгжтэй 3 талт түрээсийн гэрээг

байгуулан ажиллаж 12,9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлж хөрөнгийн ашиглалтыг сайжруулж ажилласан байна.

Орон нутгийн өмчит 181 хуулийн этгээдийн 170,2 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө орон нутгийн өмчид бүртгэлтэй байна.

#### **Хамтран ажилласан талаар:**

Сумдын ИТХ-тай орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ, аймгийн мэргэжлийн хяналтын газартай үндсэн хөрөнгө, барилга байгууламж, тээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Хамтын ажиллагааны хүрээнд Төрийн өмчид байгууллагуудад хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангаж Газрын дуудлага худалдаа, хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулахад оролцон дуудлага худалдааг хууль журмын дагуу зохион байгуулсан. Төрийн өмчийн хорооны ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл Увс аймагт ажиллахад хамтран ажиллаж төрийн өмчит аж ахуйн нэгжийн өмч эзэмшүүлэх гэрээ, хөрөнгийн тайлан онлайн программд шивсэн байдлыг хянаж, Увс аймагт ажиллах хугацаанд хамтран ажиллалаа.

Орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудын 2014 оны өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэж, сумдын иргэдийн хурлын дарга нартай орон нутгийн 2015 оны өмч эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж ажиллаа.

#### **Хөрөнгийн бүртгэл, Хяналт шалгалтын ажлын талаар:**

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалтыг сайжруулах зорилгоор БНСУ-ын буцалтгүй тусламжаар “Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн систем”-ийн программ хангамжийг боловсруулах төслийг Төрийн өмчийн хороотой хамтран хэрэгжүүлж Орон нутгийн өмчийн нэгдсэн онлайн программтай болж орон нутгийн өмч хөрөнгийг нэг бүрчлэн онлайн программд орууллаа.

Орон нутгийн өмч хөрөнгийн бүртгэлийг сайжруулах зорилгоор барилга байгууламж ашиглалтад хүлээж авах улсын комисст орж ажиллан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийг бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллаа. Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах дүрмийн дагуу Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга угсралтын ажлыг хүлээн авах 27 удаагийн Улсын комиссын бүрэлдэхүүнд орж ажиллаж хөрөнгийг эзэмшигч байгууллагын тогтоож орон нутгийн өмчид бүртгэж авсан байна. Ингэснээр 9,6 тэрбум төгрөгийн барилга, байгууламжийг хүлээн авч бүртгэжээ.

Увс эрдэм ахлах сургуулийн Уурын зуухны барилга сургуулийн барилгатай хамт үнэлгээтэй байсныг үнэлгээ тогтоох ажлын хэсэг байгуулан уурын зуухны барилгын үнэлгээ, тоног төхөөрөмжийн үнэлгээ, шугам сүлжээний үнэлгээ хийж данс бүртгэлд залруулга хийж бүртгэх ажлыг зохион байгуулсан.



Хяналт шалгалтын ажлыг сайтар зохицуулан, зохион байгуулж, түүний үр нөлөөг өндөржүүлэх асуудалд зөвхөн аймгийн ИТХурал төдийгүй холбогдох мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулахад анхаарч ирлээ.

Хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн сангийн ашиглалтыг сайжруулах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг цаг тухай бүр бүртгэн тайлагнах, ялангуяа улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах, хөрөнгийн үнэлгээг сайжруулахад анхаарч ажиллахыг сумын ИТХ-д чиглэл өгөн ажиллаж байна.

Мөн аймгийн төвийн төсөвт байгууллагуудын өмчийг хянаж шалгах ажлын төлөвлөгөө батлуулан Улаангом сумын Цогцолбор 1-р сургууль, Цогцолбор 2-р сургууль, Увс-Эрдэм ахлах сургууль, Чандмань-Эрдэм ахлах сургуулиудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгийн данс бүртгэлд хяналт шинжилгээ, тооллого хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтэд үнэлэлт өгөх, хөрөнгийн тооллого хийх, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж хяналт шалгалтын ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, бүртгэл хяналтын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажиллаа.

#### Сургалт сурталчилгааны ажлын талаар:

Жилийн ажлын төлөвлөгөөнд туссаны дагуу 19 сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарын графикт сургалт, 2015 оны оны зорилтод ажлын төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх, хамтран ажиллах, ажлыг уялдааг сайжруулах үүднээс сумдын ИТХ-ын дарга нарт 2015 оны 1-р сарын 23 нд, нарийн бичгийн дарга нарт 2015 оны 3-р сарын 13-14 нд цахим технологи, хөрөнгийн талаар мэдээлэл, сургалт хийж өмч хөрөнгийн бүртгэл хөтлөлт, хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулах, Төрийн өмчийн хорооны тогтоол болон холбогдох дүрэм журам танилцуулж зөвлөмж өгөх, Төрийн өмчийн хорооны сургалтад орон нутгийн өмчийн мэргэжилтэн оролцож холбогдох санал дүгнэлтээ хүргэж сургалтаар авсан мэдээллээ аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, нарийн бичгийн дарга нарт холбогдох мэдээллээ хүргэж ажиллаа.

Төсөвт байгууллагын ня-бо нарт хөрөнгийн программын сургалтыг MBICSoft компанитай хамтран 2015 оны 4 дугаар сарын 1-2 хооронд зохион байгуулж, төсөвт байгууллагуудын 120 гаруй нягтлан бодогч хөрөнгийн онлайн программыг ашиглах сургалтад хамруулж ажиллаа.

Хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн сангийн ашиглалтыг сайжруулах, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих, хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг цаг тухай бүр бүртгэн тайлагнах, ялангуяа улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив, тусламжаар бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах, хөрөнгийн үнэлгээг сайжруулахад анхаарч ажиллахыг сумын ИТХ-д чиглэл өглөө.

**Хувьчлалын талаар:**

Мини захын хувьчлалын гэрээний дагуу эхний жилийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажлын хэсгийн тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж 2015.08.03-ны өдрийн А/110 тоот тогтоол гарсан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 4-р сарын 15-ны өдрийн А/52 тоот тогтоолоор Увс нуурын дэргэдэх “Аялал жуулчлалын гэр бааз”-ыг менежментийн үр дүнг харгалзан хувьчлах шийдвэр гарч уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахаар аймгийн ЗДТГ-ийн Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан тендер шалгаруулах комисс байгуулан хувьчлалын үйл ажиллагааг журмын дагуу 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Уралдаант шалгаруулалтад оролцохоор 2 компани өрсөлдсөн ба 48,595.000 төгрөгийн дэнчинг урьдчилан байршуулан, тендерийн материал ирүүлснээс тендерийн комиссын үнэлгээгээр Улаанбаатар хотын Ч.Дүгэр захиралтай “Морьтны Өргөө” ХХК тендерт шалгаран гэрээ байгуулах зөвлөмжийг Аймгийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ-т ирүүлсний дагуу аймгийн ИТХ-ийн нарийн бичгийн дарга Х.Төртогтох, аймгийн ЗДТГ-ийн дарга Г.Болор-Эрдэнэ, Морьтны өргөө ХХК-ны захирал Ч.Дүгэр нар гурван талт гэрээ байгуулав. Гэрээнд зааснаар Увс нуурын дэргэдэх “Аялал жуулчлалын гэр баазын хөрөнгийн үнэлгээ 323,966.200 төгрөг ба гэрээний хугацаа 3 жил байх юм. 350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж орчин үеийн аялал жуулчлалын үйлчилгээний стандарт шаардлагыг хангасан үйлчилгээг бий болгох зорилт дэвшүүлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Тэс суманд Жишиг сум төсөл хэрэгжсэнээр сумын төвийн байгууллагууд нэгдсэн халаалт, бохирын сүлжээнд холбогдож цэвэрлэх байгууламж ажиллах болсноор 14 орон тоо бүхий “Таван Тэсийн Илч” ОНӨААТҮГ-ыг шинээр байгууллаа.

**ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ**

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн ИТХ-ын захиалгаар Үндэсний аудитын харьяа Увс аймгийн аудитын газраар

1. “Увс аймагт хийгдсэн ойжуулалт, хэрэглээний болон түлшний мод, ховор нэн ховор ан амьтныг зөвшөөрөл, эдгээрийн төлөвлөлт, гүйцэтгэл, энэ чиглэлээр төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”, “Төв суурин газрын усны үнэ тогтоолтын байдал, усны төлбөрийн байдал, усны төлбөрийн төлөвлөлт, бүрдүүлэлт”
2. “Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн”
3. “Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн, зээлийн эргэн төлөлт”-д нийцлийн болон гүйцэтгэлийн аудит хийлгэлээ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтанд тавих хяналт, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах хяналт тавих журмын хэрэгжилт хангалтгүй байна.

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр хураамжийн ноогдуулалтыг 15 сум аймгийн ИТХ-ын 2012 оны 38 тогтоолоор батлагдсан ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг мөрдөж ажиллахгүй байгаа нь орон нутгийн орлогод орох орлогын хэмжээг бууруулж байна.
- Хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах хяналт хангалтгүй байдгаас зарим сум түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан аж ахуйн нэгжид ноогдуулалт хийдэггүй, өмнөх жилүүдийн ноогдуулалт хийсэн түвшинд татварыг төвлөрүүлж байна.
- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зам барилгын угсралтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалыг тооцоолон төлөвлөлт хийдэггүйгээс түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрөөс орон нутгийн орлогод 1.7 тэрбум төгрөг төвлөрөх боломжгүй байна.
- Аймгийн хэмжээнд газар тариалангийн гэрчилгээтэй 1330 аж ахуйн нэгж байгаагаас 124 аж ахуйн нэгж, иргэн нь байгаль орчны газарт бүртгэлтэй байгаа нь усны нөөц ашигласны төлбөрийг урд оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс орон нутгийн орлогод 145.1 сая төгрөг, зам талбай барилгын ажлаас ус ашигласны төлбөр 1.5 сая төгрөг, рашааны нөөц ашигласны төлбөр төвлөрүүлэхгүй байгаад анхааран ажиллаж байна.

### **ЗУРГАА: ЦАГААТГАЛЫН КОМИССЫН АЖИЛ**

#### **Иргэдийн өргөдөл, хүсэлтэд хариу өгч, мэдэлэл зөвлөгөө өгөх чиглэлээр**

*Зөвлөгөө мэдээлэл өгсөн ажлын тойм*

№	Мэдээлэл зөвлөгөө	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт
1	Нэхэмжлэлтэй холбоотой асуудлаар уулзаж зөвлөгөө мэдээлэл авсан иргэдийн тоо	3	4	1	0	8
2	Цагаатгалын асуудлаар мэдээлэл авах, санал солилцох асуудлаар уулзсан хүнийн тоо	6	1	3	0	10
3	ТЕГ-аас авсан лавлагаа мэдээлэл	0	0	4	1	5

Увс аймгийн Давст сумаас сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгч Н.Бүрэн, маршал Ю.Цэдэнбалын гал голомт хөдөлгөөн ТББ-аас Монгол Улсын Маршал Юмжаагийн Цэдэнбалын 100 жилийн ой 2016 онд болох гэж байгаатай холбоотойгоор Ю.Цэдэнбалыг цагаатгах талаар Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2014 оны 10-р сарын 22-ны өдрийн 19 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлттэй танилцаад аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж зохих шийдвэрийг МУ-ын ерөнхийлөгч, УИХ,

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлж өгөх хүсэлтийн дагуу 3-р сарын 29 нд аймгийн ИТХ-ын Хууль эрхзүй, Дотоод хяналтын хорооны хурлаар хэлэлцэж дүгнэлт гарган Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст болон Улсын их хурлын дарга З.Энхболдод хүргүүлсэн. УИХ-ын дарга энэ асуудлыг ЗГХЭГ-т судлан шийдвэрлэх талаар хүсэлтийг шилжүүлсэн одоо болтол хариу ирүүлээгүй байгаа.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах асуудлаар 3 хүнд зөвлөгөө өгч лавлагаа магадлагаа авах тухай өргөдлийг ТЕГ-ын төв архивт албан тоотоор хүргүүлэв**

- Увс аймгийн Түргэн сумын иргэн Баярын Хорлоо, 87 настай, түүний аав Түргэн сумын харьяат Баяр овогтой Баярт нь тухайн үед Жинчин хийдэг байсан ба 1930 оны үед баривчилж явсан ба хэлмэгдсэн гэж үздэг. Уг хүнийг цагаан номны мэдээллээс хайхад цагаатгаагүй байна. Иргэн Хорлоод зөвлөгөө өгч цагаатгуулахаар материал хэрхэн бүрдүүлэх талаар зөвлөгөө өгч уг хэргийн талаарх лавлагаа магадлагаа авах өргөдлийг салбар комиссын албан тоотын хамт ТЕГ-ын тусгай архивт хүргүүлэв. ТЕГ-ын тусгай архиваас уг хүнтэй холбоотой хэргийн материал байхгүй байна гэсэн хариу ирсэн болно
- Увс аймгийн Улаангом сумын 6-р багийн иргэн Балдан овогтой Цэгмэд, 78 настай түүний ах Балдан овогтой Надмид нь улс төрийн хилс хэргээр хэлмэгдээд цагаатгагдсан ба цагаатгалын нөхөн төлбөрийг авсан боловч түүний ах Балдан овогтой Цэрэн, Балдан овогтой Түмэн гэх 2 ах нь бас баривчлагдаад цаазлагдсан ба одоо болтол цагаатгагдаагүй байгаа гэж тайлбарласан ба иргэн Б.Цэгмэдэд зөвлөгөө өгч цагаатгуулах материал бүрдүүлж өгөх талаар зөвлөгөө өгч хэргийн талаарх лавлагаа, магадлагаа авах өргөдлийг салбар комиссын албан тоотын хамт ТЕГ-ын тусгай архивт хүргүүлэв. ТЕГ-ын тусгай архиваас уг хүнтэй холбоотой хэргийн материал байхгүй байна гэсэн хариу ирсэн болно
- Увс аймгийн матчин сумын иргэн Хужаа овогтой Буян 75 настай түүний ах нацаг ах Хэмнэг овогтой Жалсарай Цалгарын хийдэд лам байгаад 1937 онд баривчлагдсан ба одоо болтол цагаатгагдаагүй гэсэн тайлбар өгсөн ба хэргийг цагаатгуулах талаар зөвлөгөө өгч хэргийн талаарх лавлагаа, магадлагаа авах өргөдлийг ТЕГ-ын тусгай архит салбар комиссын албан тоотын хамт хүргүүлэв. ТЕГ-ын тусгай архиваас уг хүнтэй холбоотой хэргийн материал байхгүй байна гэсэн хариу ирсэн болно

**Цагаатгагдсан иргэдийн нэр төрийг сэргээх талаар хэрэгжүүлсэн ажил**

Увс аймгийн Завхан сумын ИТХ-аас хүсэлт гаргаж улс төрийн хилс хэргээр хэлмэгдэж цагаатгагдсан иргэдийн судалгаа гаргуулан авсан. Энэ жил Завхан сумын 90 жилийн ой тохиож байгаатай холбоотой ИТХ-ын 2015 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө цогцолбор





бүтээн байгуулах ажлыг хэлмэгдэгч Ванягийн Ягнины зээ Г.Даваа, Б.Цэнд-Аюуш нар 3000,0 төгрөгийн төсөвт өртөгтэй хөшөө цогцолборын ажил гүйцэтгэж 90 жилийн ойн үеэр хүлээлгэн өгсөн байна.

Увс аймгийн Улаангом сумын 7-р багийн иргэн Р.Лхагвасүрэн ЦАУЗБСалбар комисст улс төрийн хилс хэрэгт

буруутгагдан ял шийтгүүлж цагаатгасан иргэдийн дурсгалыг мөнхжүүлэх, нэр төрийг сэргээх талаар тодорхой ажил ажил зохион байгуулах санал хэлж өөрөө манлайлж оролцоно гэдгээ илэрхийлсэн саналыг хүлээн авч хэлмэгдэгсдийн дурсгалын хүндэтгэх өдрөөр “Хэлмэгдүүлэлт дахин бүү давтагдаг” нэртэй ТВ нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэв.

### **ЦАУЗБСалбар комиссын мэдээллийн бааз үүгэв.**

ЦАУЗБСалбар комиссын үйл ажиллагааг хурдан шуурхай болгох, ажлын зохион байгуулалтыг сайжруулах, бүх мэдээллийг нэг дороос хурдан шуурхай авах боломж бүрдүүлэхийн тулд мэдээллийн бааз үүсгэх ажлыг 2-р улиралд хийж дуусгалаа. Энэхүү мэдээллийн баазад цагаан номонд орсон цагаатгагдсан бүх иргэдийн мэдээлэл /Овог нэр, нас, ажил алба, шийтгэсэн хуулийн зүйл анги, онгоо, тогтоолын дугаар, цагаатгасан шийдвэр, тогтоолын дугаар, онгоо, нөхөх олговор авсан эсэх, нэхэмжлэгчийн овог нэр, хэлмэгдэгчийн юу болох, шүүхийн шийдвэрийн дугаар, огноо гэсэн мэдээллийг багтаасан/-ийг нэгтгэсэн бааз үүсгэв. /файлыг хавсаргав/ Энэ нь цагаатгалын талаар иргэд мэдээлэл лавлагаа авах хүсэлтийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалдаа шинжилгээ, мэдээлэл сурталчилгаанд ашиглахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Энэ мэдээллийг цагаан номны анхны хэвлэл, 1-4 дүгээр ботид орсон Увс аймгийн иргэдийн мэдээллийг нэр бүрчлэн шивж оруулсан ба ЦАУЗБУлсын комиссын ажлын албаны мэргэжилтэн Уугансайханаас нөхөх олговрын мэдээллийг авч нэг бүрчлэн тулган мэдээллүүдийг нэгтгэж оруулсан болно

### **ЦАУЗБУлсын комиссын даргын 01 тоот албан даалгаврын биелэлтийг БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭВ**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын даргын ирүүлсэн 01 тоот албан даалгаврын дагуу аймгийн ЦАУЗБсаблар комиссын даргын тушаалаар ИТХ-ын ажлын алба аймгийн архиваас 1922-1990 оны хоорондох шүүх цаазын бичиг, эрүүгийн болон иргэний хэргүүдээс холбогдох заалтад хамаарагдах хэргүүд буюу хэлмэгдсэн байж болзошгүй хүмүүсийн судалгааг гаргах ажлыг

гэрээгээр 2 зөвлөх ажилтан томилж ажиллуулах шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн хүрээнд аймгийн ИТХ-ын ажлын албатай аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дэргэдэх архивын тасгийн сан хөмрөгч Очирсүрэн овогтой Бэгзжав, Улаангом сумын Ю.Цэдэнбалын нэрэмжит цогцолбор 1-р сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Сүхээ овогтой Баасанхүү нар 2015 оны 7 дугаар сарын 01-10-ны өдөр хүртэлх хугацаанд хамтран ажиллах гэрээг байгуулж ажиллалаа.

Гэрээний 10 хоногийн хугацаанд архивын шүүхийн баримт хадгалагдаж буй сан хөмрөгийн өрөөний 1921-1990 оны хоорондох эрүүгийн 3231 хавтаст хэрэг, 1970-1990 оны хоорондох 903 иргэний хавтаст хэргийг тус тус шүүн үзэж ЦАУЗБК-оос ирүүлсэн “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн судалгаа хийх зааварчилга”-ын дагуу холбогдох заалтуудад хамаарагдах 22 хавтаст хэргийг судлан олж бүртгэлийг улсын комисст хүргүүллээ.

1921-1950 оны хоорондох баримтууд нь таталган болон энгийн бичигдсэн гар бичмэл баримтууд байсан бөгөөд 1950 оноос хойших баримтууд нь кирилл үсгээр бичигдсэн байсан. Архивын лавлагаанд ашиглагддаггүй эдгээр баримтууд нь тоос шороо ихтэйгээс гадна өндөр тавиур дээр зай талбай багатай өрөөнд байрлаж байсан нь баримт үзэхэд хүндрэлтэй байлаа. Мөн үг үсэг бүдгэрч баларсан, анхнаасаа бүдэг бичигдсэн, зүйл заалт тодорхойгүй, огноо, тогтоолын дугаар байхгүй, хуудасны хэсэг урагдаж тасарсан, шарласан, тогтоолгүй материалууд цөөнгүй байлаа.

Өгөгдсөн заалтад хамаарах 22 хавтаст хэргээс он тодорхойгүй 2, 1931 оны 1, 1946 оны 2, 1950 оны 1, 1952 оны 9, 1959 оны 1, 1960 оны 1, 1961 оны 5 хэргээс нам засгийн бодлого шийдвэрийг эсэргүүцсэн 2, бусад нь 137-р зүйл анги буюу сүсэг бишрэлээр бусдыг мунхруулсан хэрэг байлаа.

1931-1960 оны хоорондох материалуудаас дээрх холбогдох заалтад нийцэх хэргүүдийн баримт гарч байгаа бөгөөд 1960 оноос хойших материалуудад гарсангүй.

Эрүүгийн 389 хадгаламжийн нэгжийн 3231 хавтаст хэрэг, иргэний 19 хадгаламжийн нэгжийн 903 хавтаст хэрэг, нийт 407 хадгаламжийн нэгжийн 4134 хавтаст хэргийн материалуудыг шүүн үзэж судаллаа

[Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрлөг](#)

“Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал” ТВ



нэвтрүүлэг хийв

Салбар комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар ТВ нэвтрүүлэг хийхээр орон нутгийн ТВ студын уран бүтээлч Н.Ганзориг, МУИС-ын түүхийн тэнхмын багш доктор На.Сүрбаатар, орон нутгаас хэлмэгдсэн хүмүүсийн үр хүүхдүүд, ач зээ нартай хамтран “Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал” гэсэн нэртэй телевизын 20 минутын нэвтрүүлэг бэлтгэж улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр 09-р сарын 11-нд орон нутгийн 2 ТВ-ээр нэвтрүүлж аймгийн ИТХ-ын вэб сайтанд байршууллаа / <http://uvs.khural.mn/n/9rzon/> / .

“Увс төрийн хэлмэгдүүлэлт-Увс аймагт” сэдэвт дурсгалын хилээл заав.

*Давст сумын ИТХ-ийн НБДарга Ичинхорлоо дурсгалын хилээл заав*

Хичээлийг аймгийн боловсрол соёлын газраар дамжуулан Увс аймгийн арван жилийн бүх сургуулийн ахлах ангийн сурагчдад 09-р сарын 5-9 ны хооронд тусгай боловсруулсан хөтөлбөрөөр түүхийн багш нар хичээл заав. Уг хичээлд нийт ахлах ангийн сурагчид маш идэвхтэй оролцсон ба зарим сумуудын ИТХ-ийн нарийн бичгийн дарга нар өөрсдөө хичээлийг удирдан явуулсан байна. Дурсгалийн хичээлд ахлах ангийн 180 бүлгийн нийт 4600 сурагчид хамрагдсан байна.



“Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал” сэдвээр сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд



зохион бичлэгийн уралдаан явуулав.

Зохион бичлэгийн уралдааныг аймгийн Боловсрол соёлын газрын мэргэжилтэн Доктор И.Ганболд, Увс эрдэм ахлах сургуулийн багш Б.Болдбаатар, Цогцолбор 1-р сургуулийн багш Л.Болдбаатар нар удирдан зохион байгуулж шалгаруулалтыг хийв. Уралдаанд нийт 33 сурагчийн зохион бичлэг ирснээс Зүүнговь сумын ахлах сургуулийн 10а ангийн сурагч Б.Энхсайхан, 1-р байр өргөмжлөл 60,000 төгрөг, Ахлах 3-р сургуулийн 11б ангийн сурагч Ч.Алтанчимэг 2-р байр өргөмжлөл 40,000 төгрөг, Чандмань эрдэм ахлах сургуулийн 10а ангийн сурагч П.Сэргэлэн 3-р байр өргөмжлөл 30,000 мянган төгрөг, Ахлах 3-р сургуулийн сурагч А.Тэгшбуян, Цогцолбор 1-р сургуулийн сурагч Д.Цолмонгэрэл, Д.Мэндээ нар тусгай байр эзэлж өргөмжлөл 20000 төгрөгөөр тус тус шагнагдсан байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрлөгийг Улаангом сумын ИТХ-тай хамтран зохион байгуулав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд, ач зээ нар, Улаангом сумын удирдлагууд, Маршал Ю.Цэдэнбалын гал голомт хөдөлгөөн ТББ, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд, Увс аймгийн Дэчинравжаалин хийд хамтран өдөрлөгийн арга хэмжээг уламжлал ёсоор хэлмэгдэгсдэд зориулсан 108



зул өргөж буяны ном айлтгаж ерөөл өргөх, Хэлмэгдэгсдийн дурсгалын цогцолборт хүндэтгэл үзүүлэх, арга хэмжээнд оролцсон хэлмэгдэгсдийн үр хүүхдүүд, ач зээ нарт гарын бэлэг гардуулах, аймгийн музей үзэх арга хэмжээ зохион байгуулав.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын 25 жилийн ой тохиож байгаа 2015 он Увс аймгийн Салбар комисс 2015 оны ажлаараа “ШИЛДЭГ САЛБАР КОМИСС”-оор шалгарлаа.



**ДОЛОО. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ  
ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Увс аймгийн ГХУСАЗСЗ-өөс хүний эрхийг хангах, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих чиглэлд түлхүү анхаарч гэмт хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа.



Аймгийн ГХУСАЗСЗ-өөс шүүх, прокурор болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран 3 удаагийн томоохон зөвлөгөөнийг зохион байгуулж, 2 зөвлөмж гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн хилийн болон дотоодын малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Хууль бус үйлдэл, хил дамнасан малын хулгайтай тэмцэх” сэдэвт зөвлөгөөнийг 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Увс аймгийн Улаангом хотод зохион байгуулж, Монгол Улс, ОХУ хоорондын хилийн асуудлаар байгуулсан гэрээг хэрэгжүүлэх, хоёр талын харилцан хамтын ажиллагааг дэмжих асуудлыг хэлэлцээд цаашид хамтран ажиллах 11 үндсэн чиглэлээр зөвлөмж гарган хэрэгжүүлэхээр баталсан.

Зөвлөмжийн мөрөөр гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийг иргэд олон нийтэд мэдээллийн хэрэгсэл, гарын авлага, шторк, кейс, зурагт хуудас хэлбэрээр хууль сурталчлах сургалт сурталчилгааны ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаа.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөт ажлын дагуу хууль сахиулах болон хяналтын байгууллагууд нутаг дэвсгэртээ сахилга дэг журмыг бэхжүүлэх талаар /Тариалан, Наранбулаг, Завхан, Өлгий, Өмнөговь, Ховд, Бөхмөрөн, Давст, Зүүнхангай, Цагаанхайрхан зэрэг/ сумдыг нэгдсэн удирдлагаар хангах, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилт, үр дүн, гэмт хэрэг гаралтыг бууруулах, цаг үеийн ажлаар мэдээлэл өгөх, иргэдтэй уулзах яриа таниулга хийх ажлыг хамтран зохион байгуулан ажиллалаа.

Цагдаагийн газар, хилийн цэргийн 0245-р ангид гэмт хэрэгтэй тэмцэх ажилд техникийн дэвшлийг бүтээлчээр ашиглах, гэмт хэрэг илрүүлэлтийг шуурхай болгох, таслан зогсоох, бартаа саадтай газрыг богино хугацаанд тогтоох ач холбогдол бүхий “Нисдэг камер”-ийн төхөөрөмжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд 5,800 төгрөгийн дэмжлэгийг аймгийн ГХУСАЗСЗ-ийн төсвөөс шийдвэрлэлээ.

2015 оны 07 сарын 08-нд шинэчлэн батлагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүднээс зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна

Мөн аймгийн хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд багачуудад замын хөдөлгөөнд оролцох зөв дадал, мэдлэг, хандлага төлөвшүүлэх зорилгоор School Police арга хэмжээг улирал бүр зохион байгуулж хүүхдүүдийг зам хөндлөн гарах нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлгөөнд оролцсон жолооч нарыг замын хөдөлгөөний аюулгүй байдлыг мөрдөх дадалд хэвшүүлэх үйл ажиллагааны зардалд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллаа.

Зүүнговь сумын Тохой багт хилийн цэргийн ангийн бүрэлдэхүүн хил хамгаалахад туслах хүчнийхэн болон хил орчмын бүсийн оршин суугчидтай уулзалт өдөрлөг зохион байгуулж хилчид болон малчдын санал хүсэлтийг сонсож ярилцлага зохион байгууллаа. Энэ үеэр хилийн цэргийн дуу бүжгийн чуулгын уран бүтээлчид урлагийн тоглолт хийлээ.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс “Шинэ Үндсэн хууль ба иргэний журамт үүрэг” эссэ бичлэгийн уралдааныг БСГ-тай хамтран зохион байгуулж эхний 3 байранд шалгарсан сурагчдыг шагнаж урамшууллаа.

Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс санаачлан “Мал хулгайлах гэмт хэрэг”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” – ээс урьдчилан сэргийлэх, дээрх гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор зурагт хуудас, плакат, нугалбар хэвлүүлэн Увс аймгийн 19 сум, 92 багийн хурлаар дамжуулан иргэдэд сургалт, сурталчилгаа хийж байна.

Мөн аймгийн ГХУСАЗСЗ-өөс 1800-1505 гэсэн тусгай дугаарыг цагдаагийн газрын дэргэд нээн ажиллуулж гэмт хэрэгтэй холбоотой иргэдийн санал хүсэлтийг авч байна.

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ АМАР ТАЙВАН АМЬДАРЦГАА

**Зөвхөөрөнд өргөмжлөлтэй тусал**  
 1. Зүүлтүүртэй байгаа 15-1800 хувиар өсгөлт  
 2. Бэрхшээл 17-20 жил

**Үндэсний үйлчилгээний төв**  
 1. Үндэсний үйлчилгээний төв  
 2. Гүйцэтгэгчдийн үйлчилгээний төв  
 3. Д.Д.Хүрээтэй үйлчилгээний төв  
 4. Үндэсний үйлчилгээний төв  
 5. Үндэсний үйлчилгээний төв  
 6. Үндэсний үйлчилгээний төв

**Мэдээлэл**  
 1800-1505

УВС АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

### МАЛ СҮРГЭЭ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛЪЯ

Малаа байнгын харилцаа, манатай байлгаж хавших нь мал хулгайлах гэмт хэргээс сэргийлэх хамгийн сайн арга юм.

Малын 1 биеийг эхэл үлдээх явдал ажлаар хувиар олж байсан. Малаа мал нь СХУ-ын хөл дэргээр Бяландаа болжээ түүний бүртгэл амьдралыг үндэслээр бүртгэл авах боломжтой болжээ. Хэрэв үүнийг бод мэд түүний бүртгэл, малаа эрэг бүртгэл орж байсан бол малаа агуулахгүй малаа өндөр боломжтой байжээ.

Бичигчээр: Довст, Солид, А.Умаров, В.Умаров, М.Малин, Х.Халид, сумдад 4-9 настай эрхийг хамарсан малчдын 33 бүлэг нөхөрлөл, гэрээлж малаа гүйцэтгэгчид хамтаралт гүйцэтгэл хийж байна.

Өвчинг амьлуу, эзэмшигч байгаа малаа нь тэмдэг, тэмдэгтэй байх

Бид малд тусуйн бүртгэл хийж

УВС АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

1800-1505

### МАЛ СҮРГЭЭ ГЭМТ ХАЛДЛАГААС ХАМГААЛЪЯ

Малаа байнгын харилцаа, манатай байлгаж хавших нь мал хулгайлах гэмт хэргээс сэргийлэх хамгийн сайн арга юм.

Малын та зөвхөн өнөрийн малаа харж борлуулдаг төхөөрөлд эсрэг бүтэцтэй гарам үсэг, тэмдэг бичиг өнөрийн гарам үсэг, малны тэмдэг дарж баталгаажуулж байх

Малаа бүтэн амьлуулж, шалгуулах хамгаалах мал, малчид байгаа үүсгийн гарам үсэг, бүртгэлийн гарам үсэг

Малаа хулгайд өндөр цаг хугацаа алдсуйгаар сумын удирдлагад мэдэгдэж, эрхийн бичиг, зурвас, дараан байгуулж мал хулгайлах дагалд харилцаагаар талуудын бүтэн орлогоогаар хийдэг байх

Төвлөрсөн мал зоогийн үүсгийн гэрээлэлтэй мал, малчид гэрээлэлтэй үндэс, хулгайн бүртгэлийн дотор байгаа малчид гарам үүсгийн тэмдэгтэй хавших

2014 онд 10 жилийн гаруй үүсгийн гэрээлэлтэй мал, малчид гэрээлэлтэй үндэс, хулгайн бүртгэлийн дотор байгаа малчид гарам үүсгийн тэмдэгтэй хавших

УВС АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛ

1800-1505

<p>1800-1505</p> <p>Тусгай зориулалтын автомашин</p> <p>10,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Эрэг зориулалтын автомашин</p> <p>70,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Хамгаалах бүтэцтэй автомашин</p> <p>6,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Малчид гарам үсэг</p> <p>6,000,000</p>	<p>Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</p> <p>Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</p> <p>Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</p> <p>Увс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</p>
<p>1800-1505</p> <p>Эрэг зориулалтын автомашин</p> <p>6,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Малчид гарам үсэг</p> <p>18,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Малчид гарам үсэг</p> <p>6,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Хэрэг зориулалтын автомашин</p> <p>6,000,000</p>	
<p>1800-1505</p> <p>Тусгай зориулалтын автомашин</p> <p>10,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Эрэг зориулалтын автомашин</p> <p>70,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Хамгаалах бүтэцтэй автомашин</p> <p>6,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Малчид гарам үсэг</p> <p>6,000,000</p>	
<p>1800-1505</p> <p>Тусгай зориулалтын автомашин</p> <p>10,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Эрэг зориулалтын автомашин</p> <p>70,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Хамгаалах бүтэцтэй автомашин</p> <p>6,000,000</p>	<p>1800-1505</p> <p>Малчид гарам үсэг</p> <p>6,000,000</p>	

Авилгын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2015 онд аймаг, сумын ИТХ-ын нийт 512 сонгуультан, албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгийг цаг хугацаанд нь гаргуулан авч холбогдох хяналт тавьж, АТГ-т

холбогдох тайлан мэдээг гарган хүргүүлж авилгын эсрэг хууль болон нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

### НАЙМ: БУСАД АЖИЛ

УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэнг Увс аймагт ажиллах үеэр аймгийн ИТХ-ын төлөөлөгчид уулзаж аймаг орон нутгийн хөгжлийн асуудлаар санал бодлоо солилцож, УИХ-ын гишүүний өгсөн санхүүгийн дэмжлэгээр аймгийн ИТХ-ын 15 төлөөлөгч, ажлын албаны 2 мэргэжилтэн нийт 17 хүний бүрэлдэхүүнтэй баг Тайланд улсад 6-р сарын 18-23-ны өдрүүдэд аялж тус орны барилга, зам, гүүр, аялал жуулчлал, үнэт чулууны олборлолт, боловсруулалтын ажилтай танилцаж, туршлага судлав.

Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Баруун бүсийн аймгуудын НӨУБ-ын сонгуультаан, ажилтнуудын уулзалт, спортын тэмцээн”-д багийн дүнгээр 3 байр эзэллээ.

### АЙМГИЙН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА